**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Ханхгол сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/10/СТА-ТШЗ***

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга<br>бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Аудитор: Э.Нандинчимэг<br>Утас: 7000-3775 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ЗТХС | Зам тээвэр хөгжлийн сайд |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....................................................3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....................................................5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................................................5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................................................6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................................................7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................................................8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................................................8

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....................................................9

3.Аудитын тайлан....................................................10

3.1. Ерөнхий зүйл....................................................10

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....................................................10

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....................................................10

3.4. Материаллаг байдал ....................................................10

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....................................................11

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....................................................11

3.7. Шилэн дансны мэдээлэл....................................................12

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................................................12

3.9. Аудитын илрүүлэлт....................................................12

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....................................................12

**Аудитын зөвлөмж**....................................................13

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....................................................13

**4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ** ....................................................14

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....................................................15

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 306

танай ____________-ны №______________-т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГИЙМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Халхгол сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Халхгол сумын соёлын төвийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 90 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020294

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **32,243,533.00** | **32,636,377.90** |
| **33** | **АВЛАГА** | - | 131,744.90 |
| **335** | **Бусад авлага** | - | 131,744.90 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 131,744.90 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 32,243,533.00 | 32,504,633.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,812,557.00 | 3,859,657.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,812,557.00 | 3,859,657.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,430,976.00 | 28,644,976.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 378,600.00 | 403,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,857,476.00 | 27,046,876.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,194,900.00 | 1,194,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,805,087,477.72** | **1,786,849,702.84** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,805,087,477.72 | 1,786,849,702.84 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,803,949,077.72 | 1,785,711,302.84 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,727,525,917.69 | 1,727,525,917.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (4,563,651.00) | (39,479,261.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 32,746,588.00 | 47,173,088.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12,217,446.34) | (17,523,768.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 80,415,223.26 | 94,023,407.26 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (24,281,110.89) | (32,331,637.51) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,323,557.00 | 6,323,557.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,138,400.00 | 1,138,400.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,138,400.00 | 1,138,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,837,331,010.72** | **1,819,486,080.74** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | **4,883,356.96** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 4,883,356.96 |
| **413** | **Өглөг** | - | 4,883,356.96 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 4,883,356.96 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,837,331,010.72** | **1,814,602,723.78** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,837,331,010.72 | 1,814,602,723.78 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 82,567,828.00 | 82,567,828.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 81,429,428.00 | 81,429,428.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,754,763,182.72 | 1,732,034,895.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,754,763,182.72 | 1,754,763,182.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (22,728,286.94) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,837,331,010.72** | **1,819,486,080.74** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,650,285,631.00** | **99,417,684.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,575,854,831.00** | **32,948,784.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,575,854,831.00 | 32,948,784.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,575,854,831.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,575,854,831.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 30,438,784.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 2,510,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **74,430,800.00** | **66,468,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 74,280,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 74,280,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,000.00 | 537,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 150,000.00 | 237,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 65,931,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 65,931,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **89,799,974.12** | **122,145,970.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **89,799,974.12** | **122,145,970.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 81,886,408.12 | 122,011,288.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 39,830,976.00 | 50,422,720.58 |
| 210101 | Үндсэн цалин | 39,830,976.00 | 50,422,720.58 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,450,658.00 | 6,326,091.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,803,816.31 | 4,301,742.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 414,503.94 | 506,087.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 331,603.15 | 404,868.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 81,884.96 | 101,217.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 818,849.64 | 1,012,174.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,396,200.00 | 12,690,718.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 720,000.00 | 774,718.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,676,200.00 | 11,666,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 249,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 924,400.00 | 2,996,435.01 |
| 210401 | Бичиг хэрэг | 389,500.00 | 124,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 293,400.00 | 166,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 75,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 121,500.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 120,000.00 | 207,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 2,422,035.01 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 276,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 276,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,400,000.00 | 575,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,400,000.00 | 395,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 180,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,608,174.12 | 49,000,123.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 150,000.00 | 425,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,458,174.12 | 48,575,123.87 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,913,566.00 | 134,682.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,913,566.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,913,566.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 134,682.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 134,682.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,560,485,656.88** | **(22,728,286.94)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,560,485,656.88** | **(22,728,286.94)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **74,430,800.00** | **66,468,900.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **74,430,800.00** | **66,468,900.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 74,280,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 74,280,800.00 | - |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,000.00 | 537,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 150,000.00 | 237,000.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 65,931,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 65,931,900.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **74,430,800.00** | **66,468,900.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **74,430,800.00** | **66,468,900.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **66,517,234.00** | **66,334,218.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 39,830,976.00 | 43,873,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 37,579,288.00 | 43,873,300.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,251,688.00 | - |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,450,658.00 | 8,123,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,550,858.00 | 5,716,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 380,000.00 | 481,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 95,000.00 | 601,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 475,000.00 | 120,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 949,800.00 | 1,203,500.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,396,200.00 | 12,690,718.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 720,000.00 | 774,718.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,676,200.00 | 11,666,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 249,800.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 1,013,400.00 | 646,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 400,000.00 | 149,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 293,400.00 | 166,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 75,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 47,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 120,000.00 | 207,500.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 276,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 276,000.00 | - |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,400,000.00 | 575,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,400,000.00 | 395,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 180,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 150,000.00 | 425,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 150,000.00 | 425,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,913,566.00** | **134,682.00** |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,913,566.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,913,566.00 | - |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 134,682.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 134,682.00 |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 82,567,828.00 | - | 1,754,763,182.72 | - | 1,837,331,010.72 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **82,567,828.00** | - | **1,754,763,182.72** | - | **1,837,331,010.72** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **82,567,828.00** | - | **1,754,763,182.72** | - | **1,837,331,010.72** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **82,567,828.00** | - | **1,754,763,182.72** | - | **1,837,331,010.72** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **82,567,828.00** | - | **1,754,763,182.72** | - | **1,837,331,010.72** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (22,728,286.94) | - | (22,728,286.94) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **82,567,828.00** | - | **1,732,034,895.78** | - | **1,814,602,723.78** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 74,280,800.00 | 66,367,234.00 | 65,931,900.00 | 65,797,218.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 74,280,800.00 | 66,367,234.00 | 65,931,900.00 | 65,797,218.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 74,280,800.00 | 66,367,234.00 | 65,931,900.00 | 65,797,218.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 47,495,700.00 | 39,830,976.00 | 43,873,400.00 | 43,873,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 41,437,200.00 | 37,579,288.00 | 43,873,400.00 | 43,873,300.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,058,500.00 | 2,251,688.00 | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,699,500.00 | 5,450,658.00 | 8,123,900.00 | 8,123,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,799,700.00 | 3,550,858.00 | 5,716,800.00 | 5,716,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 380,000.00 | 380,000.00 | 481,400.00 | 481,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 95,000.00 | 95,000.00 | 601,800.00 | 601,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 475,000.00 | 475,000.00 | 120,400.00 | 120,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 949,800.00 | 949,800.00 | 1,203,500.00 | 1,203,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,396,200.00 | 17,396,200.00 | 12,809,800.00 | 12,690,718.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 720,000.00 | 720,000.00 | 893,800.00 | 774,718.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,676,200.00 | 16,676,200.00 | 11,666,200.00 | 11,666,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | - | 249,800.00 | 249,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,013,400.00 | 1,013,400.00 | 424,600.00 | 409,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 400,000.00 | 400,000.00 | 63,100.00 | 63,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 293,400.00 | 293,400.00 | 166,700.00 | 166,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | - | 75,700.00 | 75,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 200,000.00 | 62,600.00 | 47,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 120,000.00 | 120,000.00 | 56,500.00 | 56,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 276,000.00 | 276,000.00 | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 276,000.00 | 276,000.00 | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,400,000.00 | 2,400,000.00 | 575,200.00 | 575,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,400,000.00 | 2,400,000.00 | 395,200.00 | 395,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | - | 180,000.00 | 180,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | - | 125,000.00 | 125,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - | 125,000.00 | 125,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 74,280,800.00 | 66,367,234.00 | 65,931,900.00 | 65,931,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 74,280,800.00 | 66,367,234.00 | 65,931,900.00 | 65,931,900.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 74,280,800.00 | 66,367,234.00 | 65,931,900.00 | 65,931,900.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **537,000.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **537,000.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 537,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 237,000.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | - | 86,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 151,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 300,000.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 300,000.00 | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Т.Гиймаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ы хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 47 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Халхгол сумын Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Алслагдмал сум учраас мэргэжлийн боловсон хүчний дутагдалд тогтмол ордог тиймээс мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, мөн шинэ Соёлын төвд нүүж орсонтой холбогдуулан 2020 онд байгууллагын дотоод гадаад тохижилтод анхаарч тавилга, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Халхгол сумын Соёлын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Халхгол сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож,

эрсдэлийн түвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 122,145.9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 2,443.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Халх гол сумын соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,844.9 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | - | 131.7 | 131.7 |
| Бараа материал | 32,243.5 | 32,504.6 | 261.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,805,087.4 | 1,786,849.7 | -18,237.7 |
| **Нийт хөрөнгө** | **1,837,331.0** | **1,819,486.0** | **-17,844.9** |
| Өр төлбөр | - | 4,883.3 | 4,883.3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 82,567.8 | 82,567.8 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,837,331.0** | **1,819,486.0** | **-17,844.9** |

Бараа материалын дансны үлдэгдэл 32,504.6 мянган төгрөг болж 261.7 мянган төгрөгөөр өссөн нь Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2,510.0 мянган төгрөгийн бүжгийн хувцас хандивлаж, 2,320.6 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,786,849.7 мянган төгрөг болж 18,237.7 мянган төгрөгөөр буурсан 30,438:7 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар хүлээн авч, 404.1 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасаж, элэгдэл тооцсоноос шалтгаалжээ.

Халх гол сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,583,816.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд ш Шинэ соёлын төвийн ашиглалтад оруулсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 40,124.8 мянган төгрөгөөр буюу 32.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 65,931.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 65,931.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,931.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант жилд гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 65,931.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн 537.0 мянган төгрөг нийт 66,468.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 66,334.2 мянган төгрөгийг зарцуулж 134.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 66,334.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.Үүнээс цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 51,997.2 мянган төгрөг буюу 78.4 хувийг эзэлж байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт үйл ажиллагаанаас 537.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, Хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Санхүүгийн тайланг хагас жилээр хугацаа хоцорч байршуулсан дүн нь 42,454.1 мянган төгрөг байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 онд ажилтан Г.Аюушид ажил хавсарсан нэмэгдэл 40 хувийг 2 сар илүү олгосон байсан актын төлбөрийг барагдуулж , и-баримттай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 46,341.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 34,425.2 мянган төгрөгийн зөрчилд 45.2 мянган төгрөгийн акт тогтоож, 34,380.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11,916.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө. .

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 34,425.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 45.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 34,380.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг

нормоор дахин тооцоолоход 45.2 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Түлш халаалтын зардалд өндөр дүнгээр төлөлт хийснээс НДШ болон ХХОАТ-ын тайлангаар 4,883.3 мянган төгрөгийн өртэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны эцэст үндсэн хөрөнгийн тооллого нь дэлгэрэнгүй бүртгэл дэх дүнгээс 17,095.6 мянган төгрөгөөр дутуу тоолсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2 дахь "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд гарсан зардлаас 12,401.1 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 11,916.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

*1.1. Илрүүлэлт:*

Түлш халаалтын зардалд гэрээнд үнийн тарифгүй 11,916.0 мянган төгрөгийн зардал төлсөн байна.

*1.2. Эрсдэл:*

Төсвийн хөрөнгийг хяналтгүй зарцуулсан байх..

*1.3. Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах..

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Хэрэгжүүлж ажиллана.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | ***Дорнод аймгийн Халхгол сумын соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: |
| **2020** | | | ДОА-2021/10/СТА-ТШЗ |

| | | |
|---|---|---|
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Дорнод аймгийн Халхгол сумын Соёлын төв** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хөрөнгийн тооллогыг тоног төхөөрөмж тооллогын бүртгэл дээр 17095.6 мянган төгрөгөөр дутуу тоологдсон байна. Тавилга эд хогшил 14781.2 мянган төгрөгөөр илүү тоологдсон байна. Номын бүртгэл 3112.1 мянган төгрөгөөр илүү тоологдсон байна. Үндсэн хөрөнгө БМ-ын ангилал хольсон. Тооллогыг эд хариуцагчаар тоолсон боловч нэгтгэсэн дүн нь зөрүүтэй байсан. | 17,095.6 | Албан шаардлага өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Гиймаа О.Болормаа |
| 2 | Нийт 145 мэдээллийг оруулсан ба Хагас жилийн санхүүгийн тайлангийн 42,454.1 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 0.0 | Албан шаардлага өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Гиймаа О.Болормаа |
| 3 | Шинэ соёлын төв нь халаалтаар ажиллах болсонтой холбоотойгоор 2020 онд Татварт өгөх 1184.1 мянган төгрөг, НДШ-д өгөх 3699,2 мянган төгрөгийн өртэй тайлагнасан бөгөөд тус газруудтай тооцоо нийлсэн акт үйлдсэн байна. | 4,883.3 | Албан шаардлага өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Гиймаа О.Болормаа |
| 4 | Тайлант онд 11,916,0 мянган төгрөгийн халаалтын зардал гарсан байна. Халаалтын төлбөрийг нэхэмжлэлийн дагуу төлдөг бөгөөд одоогоор туршилтын журмаар халаалтын ажиллагаа явагдаж байгаа учир гэрээ байгуулж тогтсон үнийн тарифыг тогтоогоогүй байна. Батлагдсан төсөвт түлш халаалтын зардлыг 11,666.2 мянган төгрөгөөр батлуулсан байна. Батлагдсан төсвөөс 249.8 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна. | 11,916.0 | Зөвлөмж өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Гиймаа О.Болормаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Харилцахаас 14,062.8 мянган төгрөгийн зардал төлөгдсөнөөс 1,519.6 мянган төгрөгийн баримт татварын цахим системд бүртгэлтэй байна. Зөрүү 12,401.1 мянган төгрөгийн баримт бүртгэгдээгүй байна. Энэ дүнд 11,916.0 мянган төгрөгийн халаалтын төлбөр багтсан байна. | 12,401.1 | Албан шаардлага өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Гиймаа О.Болормаа |
| 6 | Батлагдсан төсөв 166.5 мянган төгрөг, Зарцуулалт хэтрээгүй ч, жишиг нормоор тооцоолоход 45,2 мянган төгрөгийн илүү зарцуулалттай. | 45.2 | Төлбөрийн акт | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Гиймаа О.Болормаа |
| **ДҮН** | | **46,341.2** | | | |